



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 178

Улаанбаатар
хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3 дахь заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 26/16 дугаар зөвлөмж, Эрсдэлийн үнэлгээний 14 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9-д заасан шаардлагад нийцүүлэн холбогдох удирдамжийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

4. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төмөр замын дамжин өнгөрөх болон улс, хот хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хэвийн үйл ажиллагааг ариутгал халдваргүйжилтийн дэглэмийн хүрээнд зохион байгуулж явуулахыг холбогдох Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн Засгийн газрын холбогдох шийдвэрийг мөрдөхгүй байхаар тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын Шадар сайд

Я.СОДБААТАР

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ

ҮЙЛ АЖИЛЛАГАА	
1.	Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа
2.	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа
3.	Газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
4.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа
5.	Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагаа
6.	Банкны төлбөр, тооцооны үйл ажиллагаа
7.	Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн үйл ажиллагаа
8.	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
9.	Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагаа
10.	Шүүх, прокурорын үйл ажиллагаа
11.	Оршуулгын үйл ажиллагаа